



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/47

Бодь

**Малын шилжилт хөдөлгөөнийг
хориглох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.11, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12.1, 7.12.3, аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 12-ний өдрийн А/21 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сумын нутаг дэвсгэрт гадны аймаг, сум, өөрийн сумын баг хооронд отор нүүдэл, үйлдвэр худалдаа, үржлийн болон бусад зорилгоор амьд мал, амьтан тээвэрлэж байршуулахыг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хориглосугай.

2. Малчид, мал бүхий иргэдэд мал, амьтны шилжилт хөдөлгөөн, халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тухай сэрэмжлүүлж, ард иргэдэд уг захирамжийг танилцуулж мал, амьтны шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг сумын Мал эмнэлгийг тасаг, багийн Засаг дарга нар, Цагдаагийн хэсэгт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн Улсын байцаагч (А.Лхагвабаяр)-д даалгасугай.

4. Сумын Засаг даргын 2022 оны А/11 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Р.БАТЖАРГАЛ

642201083